

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ**

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ****НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

**2 дугаар зүйл.Төрийн аудитын хууль тогтоомж**

- 2.1.Төрийн аудитын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.
- 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Төрийн аудитын зарчим**

3.1.Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтална.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."төрийн санхүү, төсвийн хяналт" гэж төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийхийг;

4.1.2."нийтийн өмч" гэж нийтийн ашиг сонирхлын төлөө ашиглагдах иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, ургамал, ан амьтны нөөц, эрдэнэсийн сан, төсвийн орлого, нийтийн болон тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчид хамаарах эдийн болон эдийн бус хөрөнгө, хуулиар нийтийн зориулалтаар ашиглах өмчид хамаарах бусад хөрөнгийг;

4.1.3."төрийн аудитын байгууллага" гэж төрийн аудит хийх чиг үүрэг бүхий Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар, төрийн аудитын байгууллагын албан хаагчийг;

4.1.4."шалгагдагч этгээд" гэж төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчид, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг;

[Тайлбар:-Энэ заалтын "аливаа этгээд" гэснийг шалгагдагч этгээд тэдгээрийн холбогдох албан тушаалтныг ойлгоно.](#)

4.1.5."аудитад хамрагдагч" гэж шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон этгээдийг;

4.1.6."аудитын тайлан" гэж аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын дүнг илтгэсэн, эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан баримт бичгийг;

4.1.7."аудитын төлөвлөгөө" гэж аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, цаг хугацаа, хөтөлбөрийг багтаасан эрх бүхий этгээдийн баталсан баримт бичгийг;

4.1.8."санхүүгийн тайлангийн аудит" гэж шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулахыг;

4.1.9."гүйцэтгэлийн аудит" гэж шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийхийг;

4.1.10."нийцлийн аудит" гэж шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийхийг;

4.1.11."аудитын хуулийн этгээд" гэж Аудитын тухай хуулийн 3.1.4-т заасныг;

4.1.12."лог бүртгэл" гэж хэрэглэгч программд нэвтэрсэн, үйлдэл хийсэн, өөрчлөлт хийсэн, өөрчлөлт хийхийг завдсан үйлдлийн түүхийг;

4.1.13."нөлөөллийн мэдүүлэг" гэж аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг.

## **5 дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зорилт**

5.1.Төрийн аудитын үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

## **6 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх**

6.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.

6.2.Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зөвхөн энэ хуулиар тогтоох бөгөөд бусад хуулиар төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүрэг нэмэгдүүлэхийг хориглоно.

6.3.Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1.шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

6.3.2.Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

6.3.3.төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

6.3.4.нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх.

6.4.Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргаас итгэмжилсэн аудитор аудит хийх бөгөөд уг аудитыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

6.5.Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бусад төрөл, хэлбэрээр аудит хийж болно.

6.6.Аудитад хамрагдагчийн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон тухайн үйл ажиллагаа төрийн аудитад хамрагдана.

6.7.Энэ хуулийн 6.3.3-т заасан эрхийг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 12.1 дэх хэсэг хамаарахгүй.

6.8.Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

[/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ТӨРИЙН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

## **7 дугаар зүйл.Төрийн аудитын төрөл, хэлбэр**

7.1.Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд дараах төрлөөр аудит хийнэ:

7.1.1.санхүүгийн тайлангийн аудит;

7.1.2.гүйцэтгэлийн аудит;

7.1.3.нийцлийн аудит.

7.2.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 7.1-д заасан аудитыг нэгдсэн, хамтарсан, зэрэгцээ, баталгаажуулах, мэдээллийн технологийн болон бусад хэлбэрээр хийж болно.

7.3.Санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

## 8 дугаар зүйл. Санхүүгийн тайлангийн аудит

- 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.
- 8.2. Төрийн аудитын байгууллага төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.
- 8.3. Төрийн аудитын байгууллага Улсын Их Хурлын зөвхөн санхүүгийн тайланд аудит хийнэ.
- 8.4. Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.
- 8.5. Аудитын хуулийн этгээд энэ хуулийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийхдээ төрийн аудитын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.
- 8.6. Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан шууд ба шууд бус зардлыг нөхөх зорилгоор шалгагдагч этгээдээс аудитын үйлчилгээний төлбөр авна. Аудитын үйлчилгээний төлбөрийн жишиг үнийг Монгол Улсын Ерөнхий аудиторын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоож, холбогдох байгууллагуудын төсөвт тусгана.
- 8.7. Энэ хуулийн 8.4-т заасан аудитын хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулах бөгөөд аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

## 9 дүгээр зүйл. Гүйцэтгэлийн аудит

- 9.1. Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ.
- 9.2. Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.

## 10 дугаар зүйл. Нийцлийн аудит

- 10.1. Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд аудит хийнэ.
- 10.2. Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийнэ.
- 10.3. Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудиттай хослуулан хийж болно.

## 11 дүгээр зүйл. Аудитын төлөвлөлт

- 11.1. Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 11.2. Энэ хуулийн 11.1-д заасан аудитын сэдвийг дараах байдлаар ангилна:
  - 11.2.1. хуульд заасны дагуу хийгдэх аудит;
  - 11.2.2. төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудит.
- 11.3. Энэ хуулийн 11.2.1-д зааснаас бусад аудитын сэдвийг батлахдаа дараах хүчин зүйлд үндэслэнэ:
  - 11.3.1. тухайн сэдвээр урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдсэн байх;
  - 11.3.2. төсөв, санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхтай байх;
  - 11.3.3. иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх.
- 11.4. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар тухайн орон нутагтаа гүйцэтгэх дөрвөөс илүүгүй аудитын сэдвийг энэ хуулийн 11.3-т заасан хүчин зүйлийг үндэслэн боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудитороор батлуулна.
- 11.5. Энэ хуулийн 11.1, 11.4-т заасан аудитын сэдвийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын төлөвлөгөөг жилийн болон хэтийн хугацаагаар боловсруулж батална.

## 12 дугаар зүйл. Төлөвлөгөөт бус аудит

- 12.1. Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөт бус аудитыг Улсын Их Хурлын шийдвэр, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хянан шалгах түр хорооны шийдвэр болон хуульд заасан бусад үндэслэлээр хийнэ.  
[Тайлбар:-Энэ хэсгийн "хуульд заасан бусад үндэслэл" гэснийг Нийтийн сонсголын тухай хуулийн 9.2-т "Төсвийн хяналтын сонсгол явуулах бол төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна" гэх зэргээр хуульд тусгайлан заасан асуудлаар төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэхээр заасан тохиолдлыг ойлгоно.](#)

12.2.Энэ хуулийн 12.1-д заасны дагуу холбогдох этгээд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэх тохиолдолд энэ талаар Монгол Улсын Ерөнхий аудиторт урьдчилан мэдэгдэж, зөвшилцсөний үндсэн дээр уг аудитын хамрах хүрээ, хугацааг тогтооно.

### 13 дугаар зүйл.Аудитад цахим мэдээлэл, арга зүйг ашиглах

13.1.Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашигтай аудитыг хийхийн тулд шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.

13.2.Төрийн аудитын байгууллага аудит хийхэд шаардлагатай цахим мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг ашиглах бөгөөд түүний ашиглалт, хөгжүүлэлтийг дунд болон урт хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

13.3.Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн цахим мэдээллийн сан, мэдээлэл, гүйлгээ, бүртгэл зэрэгт цахим хэлбэрээр хийгдсэн төрийн санхүү, төсвийн төлөвлөлт, тайлагналт, ашиглалт, зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнд цахим мэдээллийн нэгдсэн систем ашиглан аудит хийж болно.

13.4.Аудитад цахим мэдээллийн нэгдсэн системийг ашиглах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

### 14 дүгээр зүйл.Төрийн аудитын стандарт

14.1.Төрийн аудитын байгууллага чиг үүргээ гүйцэтгэхдээ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий этгээдээс баталсан стандартыг баримтална.

14.2.Үндэсний аудитын газрын дэргэд төрийн аудиттай холбоотой стандарт, аргачлал, удирдамж, зааврыг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус гишүүдээс бүрдсэн Төрийн аудитын стандартын хороо ажиллана.

14.3.Төрийн аудитын стандартын хороо Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр томилогдсон эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн болон бусад чиглэлээр мэргэшсэн 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

14.4.Төрийн аудитын стандартын хороо дараах чиг үүрэгтэй:

14.4.1.төрийн аудитын олон улсын стандартын албан орчуулгыг хянан, хэрэглээний тайлбар, зөвлөмж гаргах;

14.4.2.төрийн аудитын үндэсний стандарт боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

14.4.3.төрийн аудитын байгууллагаас аудит хийхтэй холбоотой дотоод аргачлал, удирдамж, заавар гаргах.

14.5.Төрийн аудитын стандартын хорооны дүрэм, хорооны гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

### 15 дугаар зүйл.Мэдээлэл авах эрх

15.1.Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ мэдээллээр бүрэн хангагдах зарчмын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах;

15.1.2.шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн ажлын байр болон бусад холбогдох газарт ажлын цагаар саадгүй нэвтрэн орох, ажиллах, бүртгэл, тооллого хийх, мэдээлэл, баримт бичиг, аливаа эд зүйлстэй үнэ төлбөргүйгээр танилцах;

15.1.3.шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, түүний эх код, цахим мэдээллийн сан, лог бүртгэлд нэвтрэх, цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан мэдээлэл, баримт бичигтэй танилцах, уг мэдээлэл, баримт бичгийг цахим болон бусад хэлбэрээр хувиран авах;

15.1.4.шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчаас тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж, хариулт авах;

15.1.5.энэ хуулийн 13.2-т заасан системийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас аудитад шаардлагатай мэдээллийг гаргуулах.

15.2.Энэ хуулийн 6.4-т зааснаас бусад тохиолдолд төрийн аудитын байгууллага аудит хийхдээ зөвхөн Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, түүнчлэн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийн зөвхөн тухайн харилцаатай холбогдох хэсэгтэй хуульд заасан журмын дагуу танилцах, хэвлэх, олшруулж авах эрхтэй.

[/Энэ хэсэгт "байгууллага, хувь хүний нууцад" гэснийг "байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд" гэж 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

15.3.Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичигтэй танилцсан төрийн аудитын байгууллагын албан хаагч уг мэдээлэл, баримт бичгийг холбогдох хуульд заасны дагуу нууцлах үүрэг хүлээнэ.

/Энэ хэсэгт "албаны, байгууллага, хувь хүний нууцад" гэснийг "албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд" гэж 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно.

15.5.Төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

#### **16 дугаар зүйл.Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үүрэг**

16.1.Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй:

16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах;

16.1.2.төрийн аудитын байгууллагын албан хаагчийг ажлын байр, холбогдох бусад газар, цахим мэдээллийн санд чөлөөтэй нэвтрүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх;

16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;

16.1.5.төрийн аудитын байгууллагын албан хаагчтай харилцах, туслах үүргийг тодорхой ажилтанд хариуцуулах;

16.1.6.хуульд заасан бусад үүрэг.

#### **17 дугаар зүйл.Аудитад шинжээч оролцуулах**

17.1.Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно.

17.2.Шинжээч аудитыг хийхэд шаардагдах тодорхой ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвартай этгээд байна.

17.3.Шинжээч төрийн аудитын байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд ажиллана.

17.4.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 17.2-т заасан шинжээчийн мэдээллийн санг үүсгэж, өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

17.5.Шинжээчийг сонгохдоо аудит хийх тухайн салбар, чиглэлээр мэргэшсэн байдал, хөндлөнгийн болон хараат бус байх шаардлагыг үндэслэл болгоно.

17.6.Энэ хуулийн 17.1-д заасан шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

17.7.Шинжээчийг ажиллуулах зардал нь төрийн аудитын байгууллагын тухайн жилийн төсвийн урсгал зардлын 20 хувиас хэтрэхгүй байна.

#### **18 дугаар зүйл.Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авах**

18.1.Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн төслийг шалгагдагч этгээдэд хүргүүлнэ.

18.2.Шалгагдагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.

18.3.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 18.2-т заасны дагуу шалгагдагч этгээдээс ирүүлсэн саналыг үндэслэлтэй гэж үзвэл тайланд засвар оруулах, үндэслэлгүй гэж үзвэл аудитын тайланг нэмэлт нотлох баримтаар бататгах арга хэмжээг авна.

18.4.Шалгагдагч этгээд энэ хуулийн 18.2-т заасан хугацаанд аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй бол саналгүйд тооцно.

#### **19 дүгээр зүйл.Аудитад хамрагдагчийн тайлбар, саналыг сонсох**

19.1.Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн дүнгийн улмаас аудитад хамрагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй тохиолдолд энэ талаар санал, хүсэлт, тайлбар, гомдол гаргах боломжийг олгоно.

#### **20 дугаар зүйл.Төрийн аудитын тайлан**

20.1.Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.

20.2.Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө.

20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.

20.4.Төрийн аудитын байгууллага аудитын тайланг шалгагдагч этгээд, Улсын Их Хурал, шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.